



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/552

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн Ховд аймгийн Манхан, Мянгад сумдад малын зөөврийн хашааг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ц.Нанжид - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга


Ц.Буянжаргал - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Нярав, бичиг хэргийн эрхлэгч

Нарийн бичгийн дарга: Г.Бат-Өлзий - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга

2. Малын зөөврийн хашааг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Тухайн ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Zah A/552 Kh  
02 2751